



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А-203

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар "Эрүүл хүнс - Малчны хотноос" хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан мах, сүүний болон сарлагийн цөм сүргийн үржлийн аж ахуйд шаардагдах үржлийн үхэр болон сарлаг, малын үржүүлэг технологийн багаж хэрэгсэл хүлээн авах болон "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт" төслийн хөрөнгөөр импортоор нийлүүлсэн цөм сүргийн малыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Гэрээгээр нийлүүлэгдэж буй бараа, ажил, үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтын шаардлага, ажлын даалгаварт нийцүүлэн шалган хүлээн авч, дүгнэлт гаргаж, танилцуулж ажиллахыг ажлыг хэсэг /Д.Батсүрэн/ үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000800



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн яамны Төрийн нарийн  
бичгийн даргын 2021 оны 06 дугаар  
сарын 17-ны өдрийн А.203 дугаар  
тушаалын хавсралт

НЭГ. ЭРҮҮЛ ХҮНС - МАЛЧНЫ ХОТНООС" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
ХУДАЛДАН АВСАН МАХ, СҮҮНИЙ БОЛОН САРЛАГИЙН ЦӨМ СҮРГИЙН  
ҮРЖЛИЙН АЖ АХУЙД ШААРДАГДАХ ҮРЖЛИЙН ҮХЭР БОЛОН САРЛАГ, МАЛЫН  
ҮРЖҮҮЛЭГ ТЕХНОЛОГИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч

- Малын генетик нөөцийн хэлтсийн дарга Д.Батсүрэн

Гишүүд

- Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг
- Малын удмын сангийн үндэсний төвийн Үйлдвэрлэл технологийн албаны дарга Н.Бархас
- Малын удмын сангийн үндэсний төвийн мэргэжилтэн В.Санчир
- Малын удмын сангийн үндэсний төвийн нягтлан бодогч Б.Отгонжаргал
- Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга Ж.Цогтбаатар /тохиролцсноор/

Нарийн бичгийн дарга

- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан

ХОЁР. "ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ НЭМЭЛТ  
САНХҮҮЖИЛТ" ТӨСЛИЙН ХӨРӨНГӨӨР ИМПОРТООР НИЙЛҮҮЛСЭН  
ЦӨМ СҮРГИЙН МАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч

- Малын генетик нөөцийн хэлтсийн дарга Д.Батсүрэн

Гишүүд

- Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг
- Малын удмын сангийн үндэсний төвийн Үйлдвэрлэл технологийн албаны дарга Н.Бархас
- Малын удмын сангийн үндэсний төвийн мэргэжилтэн В.Санчир
- Малын удмын сангийн үндэсний төвийн нягтлан бодогч Б.Отгонжаргал
- "Зах зээл ба бэлчээр удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт" төслийн бүрэлдэхүүн хэсгийн дэд зохицуулагч С.Гүн-Уянга

Нарийн бичгийн дарга

- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан